	"Ерөнхий боловсролын Хобби сургууль" БСБ	**Боловсруулсан:** ..... [Ө.Баттүшиг, Хүүхэд хөгжлийн менежер] ..... [Д.Батдорж, Ахлах ангийн нийгмийн ажилтан]	**Дугаар:** Д-172-03
		Хянасан:..... [Г.Эрдэнэцэцэг, Сургалт хариуцсан захирал	**Хуудасны тоо:** 8
		Баталсан:..... [Г.Цэлмүүн, Захирал]	**Баталсан огноо:** 2017/05/08

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХОББИ СУРГУУЛЬ БСБ

СУРАЛЦАГЧИЙН ДҮРЭМ

(Нээлттэй)

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр
Бүх бүлэг	Суралцагчийн эрх, үүрэг	01	2024/05/20	Хүүхэд хөгжлийн менежер Ө.Баттүшиг	Захирал Г.Цэлмүүн
Бүх бүлэг	Суралцагчийн эрх, үүрэг, зөрчил, зөрчил шийдвэрлэх арга	02	2026/04/30	Хүүхэд хөгжлийн менежер Ө.Баттүшиг, Ахлах ангийн нийгмийн ажилтан Д.Батдорж	Захирал Г.Цэлмүүн

1. Нийтлэг үндэслэл

1.1. Зорилго

"Хобби" сургуулийн суралцагчийн Дүрмийн зорилго нь Сургуулийн эрхэм зорилго, үнэт зүйлст тулгуурлан сурлага, хүмүүжлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, боловсролын чанар стандартыг сайжруулах, суралцагчдын сурч боловсрох цагийг зүй зохистой, зориулалтын дагуу ашиглуулах үүднээс тэдний сурах явцад баримтлан сахих соёл, сахилга бат, хүмүүжлийн хэм хэмжээг тогтооход оршино.

1.2. Хамрах хүрээ

Энэхүү дүрэм нь:

- Сургуулийн гадаад, дотоод орчин, нийгмийн болон цахим орчин
- Сургуулиас зохион байгуулсан хичээл, сургалт клуб, дугуйлан, арга хэмжээ, аялал, уралдаан тэмцээн,
- Сургуулийг төлөөлөн оролцож буй үйл ажиллагаанд мөрдөгдөнө.

1.3. Бидний баримтлах 5 үнэт зүйл

Үнэт зүйл	Сурагчийн өдөр тутмын үйлдэл
Шударга байдал	Үнэнч байх, хууран мэхлэхгүй, өөрийн хийсэн ажлыг өөрөө хариуцах
Төгс төгөлдөр байдал	Өдөр бүр өөрийгөө сайжруулж, хичээлдээ хариуцлагатай байх
Эрх тэгш байдал	Бусдыг ялгаварлахгүй, хүн бүрийг хүндэтгэх
Эх оронч үзэл	Монгол хэл, соёл, сургууль, улс орныхоо нэр хүндийг эрхэмлэх
Аюулгүй байдал	Өөрийн болон бусдын бие, сэтгэл зүйн аюулгүй байдлыг хамгаалах

2. Суралцагчийн эрхэм зорилго

"Хобби" сургуулийн суралцагчийн ЭРХЭМ ЗОРИЛГО нь өөрийн бие, оюун санааг дайчлан эрдэмд шамдан суралцаж, ихийг олж мэдэхийн зэрэгцээ сурсан мэдсэн зүйлээ бусдын сайн сайхны төлөө зориулдаг, хүнлэг, сайхан сэтгэлтэй, оюунлаг, урлаг ойлгож бишрдэг, бүтээлч, эх оронч иргэн болж, Монгол Улс болон сургуулийнхаа нэр хүндийг ямагт өндөрт авч явахад оршино.

3. Суралцагчийн эрх:

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон. Доорх заалтууд тус конвенцийн үндсэн 4 зарчим — ялгаварлан гадуурхахгүй байх, хүүхдийн эрх ашгийг дээдлэх, амьд явах ба хөгжих эрх, оролцох эрх дээр суурилсан болно.

3.1 Сургуулийн баталсан хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагаанд хамрагдах;

3.2 Сургуулийн хөтөлбөр, боломжийн хүрээнд клуб, дугуйлан, секц, уралдаан, тэмцээн, уулзалт, төсөл, хөтөлбөрт оролцох;

3.3 Сургуулийн сургалтын танхим, нийтийн эзэмшлийн газрыг зохих журмын дагуу ашиглах;

3.4 Ном, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн ашиглах, хэрэглэх;

3.5 Сургууль, сургалтын үйл ажиллагаа, клуб, дугуйлан, секц, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх ажилтай холбоотой санал, санаачилга гаргах;

3.6 Сурагчдын зөвлөл, ангийн дарга, сургуулийн олон нийтийн үйл ажиллагаанд тэгш оролцох, нэр дэвших, сонгогдох;

3.7 Өөрт нь нөлөөлөх сургуулийн шийдвэр, дүрэм журамтай холбоотой санал бодлоо чөлөөтэй, хүндэтгэлтэй илэрхийлж, сонсогдох;

3.8 Дүн үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд сургалтын албанд хандан магадлуулах, үндэслэлтэй хүсэлт гаргаж, нягтлуулах;

3.9 Өөрийн сурлагын ахиц, хөгжлийн талаар мэдээлэл авч, сайжруулах зөвлөгөө авах;

3.10 Өөрийн нэр хүнд, бие, эрүүл мэндийг хамгаалах, хамгаалуулах;

3.11 Сургуулийн тогтоосон журмын дагуу өдрийн хоол идэх;

3.12 Өөртэй нь холбоотой дэмжлэг, хамгааллын асуудлыг нууцлалтай авч үзүүлэх;

3.13 Үзэл бодол, итгэл үнэмшлээ бусдын эрхэд халдахгүйгээр чөлөөтэй илэрхийлэх;

3.14 Нийгэм, сургалт, сэтгэл зүйн талаар сургууль болон сургуулийн багш, ажилтнуудаас холбогдох дэмжлэг туслалцаа авах.

3.15 Санал, хүсэлт, гомдлоо илэрхийлсний төлөө ялгаварлан гадуурхагдахгүй, шийтгэгдэхгүй байх;

4. Суралцагчийн үүрэг

Суралцагч нь өөрийн сурч хөгжих эрхээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ, бусдын болон сургуулийн өмнө дараах үүргийг хүлээнэ:

4.1. Үндсэн үүрэг

4.1.1 Сургуулиас тогтоосон дүрэм, журам, заавар, удирдамжийг дагаж мөрдөх;

4.1.2 Сургуулийн захиргаа, багш, ажилтны тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлэх;

4.1.3 Суралцах үйл ажиллагаанд хариуцлагатай оролцож, хичээл, даалгавар, дугуйлан, секц, сонгон болон сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвх санаачилгатай хандах;

4.1.4 Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хувийн орон зайг хүндэтгэж, хүн бүртэй эелдэг, хүндэтгэлтэй, соёлтой харилцах;

4.1.5 Сургуулийн байр, анги танхим, нийтийн эзэмшлийн талбай, эд хөрөнгө, орчныг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, зориулалтын дагуу гамтай ашиглах;

4.1.6 Сургуулийн орчинд өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх;

4.1.7 Өвдсөн, бэртсэн, биеийн байдал тавгүй болсон, эсхүл осол, гэмтэл, галын аюул, зөрчил, гадны сэжигтэй хүн болон бусад эрсдэлтэй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд багш, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, холбогдох ажилтанд шуурхай мэдэгдэх;

4.1.8 Дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, цахим дарамтын шинжтэй үйлдлийн талаар мэдсэн тохиолдолд өөрийн аюулгүй байдлыг ханган багш, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын багт нэн даруй мэдэгдэх;

4.1.9 Шалгалт, сорил, бие даалт, төсөл, бүтээлийг өөрийн хөдөлмөрөөр гүйцэтгэж, бусдаас хуулах, бусдад хуулуулах, бусдын бүтээл, санаа, эх сурвалжийг зөвшөөрөлгүй өөрийн мэт ашиглахгүй байх;

4.1.10 AI болон цахим эх сурвалжийг багшийн зөвшөөрөл, зааварчилгааны дагуу ашиглаж, ашигласан тохиолдолд эх сурвалж, хэрэглээг үнэн зөв дурдах;

4.1.11 Сургуулийн цахим систем, цахим орчинд өөрийн болон бусдын нэр төр, хувийн мэдээлэл, аюулгүй байдлыг хүндэтгэн хариуцлагатай оролцох;

4.1.12 Хорт зуршил, сөрөг нөлөөлөл бүхий орчин, эрсдэлтэй нөхөрлөл, хууль бус болон зүй бус үйлдлээс татгалзах.

4.2 Суралцагчийн өдөр тутамд баримтлах дэг

4.2.1 Хичээл, сургалтын хүрээнд

4.2.1.1 Хичээл эхлэхээс өмнө сургуульдаа ирж, анги танхимдаа орон суудлаа эзэлсэн байх;
4.2.1.2 Сургуульд ирэхдээ хичээлийн бэлтгэлээ бүрэн хангах;
4.2.1.3 Хичээлийн явцад анхааралтай оролцож, хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь эзэмшихийг эрмэлзэх;
4.2.1.4 Гэрийн даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэх;
4.2.1.5 Сургуулийн цахим системээс гэрийн даалгавар болон шаардлагатай мэдээлэлтэй тогтмол танилцах;
4.2.1.6 Тасалсан, завсардсан хичээлийн агуулгыг нөхөн судалж, шаардлагатай тохиолдолд шалгуулах;
4.2.1.7 Дугуйлан, секц, сонгон хичээлд бүртгүүлсэн тохиолдолд хариуцлагатай, тогтмол оролцож, оролцох боломжгүй бол урьдчилан мэдэгдэх;
4.2.1.8 Багшийн заавар, цаг баримтлал, харилцааны ёс зүйг өдөр тутамдаа мөрдөх.

4.2.2 Чөлөө авах, сургуулийн байр, хашааг орхих хүрээнд
4.2.2.1 Чөлөөг зөвхөн эцэг эх, асран хамгаалагчаар дамжуулан авах;
4.2.2.2 Хичээлийн цагаар хариуцсан багш, ажилтны зөвшөөрөлгүй анги, сургуулийн байр, хашааг дур мэдэн орхихгүй байх;
4.2.2.3 Хичээл, сургалтын үйл явцын дундуур сургуулийн байрнаас гарах зайлшгүй тохиолдолд сургалтын менежерээс бичгээр зөвшөөрөл авах.

4.2.3 Харилцаа, зан үйлийн хүрээнд
4.2.3.1 Өөрийн зан үйл, үг хэл, үйлдлээ хянаж, асуудал, үл ойлголцол, маргааныг тайван, соёлтой, харилцан хүндэтгэлтэйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх;
4.2.3.2 Суралцагч бүр сургуулийн нүүр царай гэдгээ ухамсарлаж, сургуулийн нэр хүндийг эрхэмлэн олон нийтийн газар биеэ зөв боловсон, хариуцлагатай авч явах;
4.2.3.3 Үзвэр, тоглолт, уулзалт, хурал, арга хэмжээ, үйлчилгээний үед соёлтой оролцож, бусдад саад болохгүй байх;
4.2.3.4 Цахим орчинд боловсон, соёлтой, хариуцлагатай харилцах.
4.2.3.5 Бага ангийн суралцагч нь гараас гарт журмыг баримтлан эцэг, эх асран хамгаалагчийн хамт явах.

4.2.4 Дүрэмт хувцас, гадаад төрхийн хүрээнд
4.2.4.1 Даваа–Пүрэв гарагт сургуулийн дүрэмт хувцсыг зааврын дагуу, цэвэр, нямбай өмсөх;
4.2.4.2 Охидын банзлын урт нь өвдөгнөөс дээш 5 см-ээс илүүгүй байх;
4.2.4.3 Охид өмд өмсөх тохиолдолд сургуулийн дүрэмт хувцасны батлагдсан өнгийн өмд өмсөх бөгөөд жинсэн болон өөр өнгийн өмд өмсөхгүй байх;
4.2.4.4 Баасан гарагт сургуулиас зөвшөөрсөн чөлөөт хувцсыг эсвэл дүрэмт хувцасаа цэвэр, зохистой, сургалтын орчинд нийцүүлэн өмсөх;
4.2.4.5 Хумсаа цэвэр , арчилсан / 2 мм-ээс уртгүй/, аюулгүй байлгах;
4.2.4.6 Үс засалтаа цэвэр, эмх цэгцтэй, сургалтын үйл ажиллагаанд саад болохгүй байлгах;
4.2.4.7 Нүүр будалт, гоёл чимэглэлээ сургалтын орчинд зохистой байлгах.

4.2.5 Хооллох үеийн хүрээнд
4.2.5.1 Хооллохын өмнө гараа угааж орох;
4.2.5.2 Хоолны газрын журмыг чандлан сахих;

4.2.5.3 Хоолыг зохистой хэмжээгээр авч, аль болох үлдээхгүй идэхийг хичээх;
4.2.5.4 Хоол, цайг асгахгүй, хаяхгүй байх;
4.2.5.5 Хооллосон аяга, тавгаа бохир хураах хэсэгт эмх цэгцтэй хураах;
4.2.5.6 Сургуулийн үдийн хоол иддэггүй суралцагч үдийн хоолны цагаар сургуулийн хашаанаас гарч хоол авахгүй, гэрээсээ бэлтгэж ирсэн хоолоо зориулалтын газарт идэх;
4.2.5.7 Бүх хоол, хүнсийг зөвхөн зориулалтын газарт идэх ;

4.2.6 Сургуулийн дотоод орчин, эрүүл ахуйн хүрээнд

4.2.6.1 Сургуулийн дотоод орчны цэвэр байдал, эрүүл ахуйн дэгийг сахих;
4.2.6.2 Сургуулийн байранд нэвтрэхдээ гадуур өмссөн гутлаа солих;
4.2.6.3 Локер болон хувийн хэрэглээний орчноо цэвэр, эмх цэгцтэй ашиглах;
4.2.6.4 Сургуулийн шат, хонгил, коридорт баруун гарын дүрмээ баримтлан, бусадтай мөргөлдөж бэртэх, бэртээхээс сэргийлэх;
4.2.6.5 Анги танхим, нийтийн эзэмшлийн талбай, сургуулийн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг гамтай ашиглах.
4.2.6.6 Нийтийн эзэмшлийн талбай, өрөө тасалгаа /ариун цэврийн өрөө, номын сан, урлаг заал, спорт заал, коридор зэрэг/-г зориулалтын дагуу ашиглаж, дараагийн ашиглах хүндээ төвөг учруулахгүйгээр цэвэр, эмх цэгцтэй үлдээх.

4.2.7 Унадаг дугуй, скүүтэр, цахилгаан дугуй ашиглах хүрээнд

4.2.7.1 14-өөс дээш насны суралцагч сургуульд унадаг дугуй, цахилгаан скүүтэрээр ирэх тохиолдолд нийгмийн ажилтнаас зөвшөөрөл авах;
4.2.7.2 16-аас дээш насны суралцагч цахилгаан дугуйгаар сургуульд ирэх тохиолдолд нийгмийн ажилтнаас зөвшөөрөл авах;
4.2.7.3 Аливаа дугуйт хэрэгслийг зориулалтын зогсоолд байрлуулах;
4.2.7.4 Аливаа дугуйт хэрэгслийг зөвхөн зориулалтын замаар унах;
4.2.7.5 Сургуулийн хашаанд өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах;
4.2.7.6 Сургуулийн хашаан дотор дугуйт хэрэгслийг унахгүй, явган түрж хөдөлгөх.

4.2.8 Нийтээр дагаж мөрдвөл зохиох бусад дэг журмыг сахих.

5. Суралцагчдад хориглох зүйл ба зөрчил

Суралцагчийн зөрчилд энэхүү дүрмийн 4 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй явдал болон энэхүү 5 дугаар зүйлд заасан хориглосон үйлдэл, эс үйлдэл хамаарна.

5.1 Өдөр тутмын дэг, сахилгын зөрчил.

Дараах үйлдлүүдийг хориглоно:

5.1.1 Хичээлд шаардлагатай ном, дэвтэр, хэрэглэгдэхүүн, даалгавар, бэлтгэлээ хангаагүй ирэх;
5.1.2 Хичээл, сургалтын үйл ажиллагаанд хоцрох;
5.1.3 Хичээл, сургалтын үед багшийн зөвшөөрөлгүй дуу чимээ гаргах, зөвшөөрөлгүй анги дотор явах, орж гарах, бусдад саад учруулах;
5.1.4 Багш, нийгмийн ажилтан болон бусад ажилтны тавьсан зүй ёсны шаардлага, үүрэг, даалгаврыг үл тоомсорлох, үл биелүүлэх;
5.1.5 5-12 насны суралцагчид смарт утас сургуульд зөвшөөрөлгүй авч ирэх;
5.1.6 Сургуулийн орчинд багш, ажилтны зөвшөөрөлгүй гар утас, таблет, чихэвч, зөөврийн компьютер болон бусад төхөөрөмж ашиглах;
5.1.7 Багшийн өгсөн гэрийн даалгавар, ангийн ажил, сургалтын даалгаврыг шалтгаангүйгээр биелүүлэхгүй байх;

5.1.8 Сургуулийн цахим системд байршуулсан гэрийн даалгавар, зар мэдээ, мэдээлэлтэй танилцах үүргээ биелүүлэхгүй байх;
5.1.9 Тасалсан, завсардсан хичээлийн агуулгыг нөхөн судлах, шалгуулах үүргээ биелүүлэхгүй байх;
5.1.10 Дугуйлан, секц, сонгон хичээлд бүртгүүлсэн боловч шалтгаангүйгээр таслах, урьдчилан мэдэгдэлгүй оролцохгүй байх;
5.1.11 Сургалтын явцад унтах, хичээлд саад учруулах;
5.1.12 Хориглосон газар хоол хүнс хэрэглэх;
5.1.13 Хоолны газрын журам, цэвэр байдал, эрүүл ахуйн шаардлагыг зөрчих, хооллосны дараа аяга, хэрэгслээ зориулалтын хэсэгт хураахгүй байх;
5.1.14 Сургуулийн байранд нэвтрэхдээ гутал солих, дотоод орчны цэвэр байдлыг сахих шаардлагыг биелүүлэхгүй байх;
5.1.15 Өөрт оногдсон локерыг зориулалтын бусаар ашиглах, бохирдуулах, бусдын локерт зөвшөөрөлгүй хүрэх;
5.1.16 Гэрийн тэжээвэр амьтан болон хорхой, шавж, амьтан багшийн зөвшөөрөлгүй авч ирэх;
5.1.17 Сургалтын үйл ажиллагаанд шаардлагагүй өндөр үнэ бүхий эд зүйл, их хэмжээний мөнгө авч ирэх;
5.1.18 Хөзөр, мөрийтэй болон зохисгүй тоглоом тоглох;
5.1.19 Бүдүүлэг, хараалын үг хэлэх;
5.1.20 Зориулалтын бус газарт хог хаях;
5.1.21 Исгэрэх, шүгэлдэх, чанга дуугарах, орилох, хашгирах;
5.1.22 Цайны газар болон нийтийн эзэмшлийн орчинд чанга дуу чимээ гаргах, гүйж харайх, бусдад саад учруулах;
5.1.23 Дүрэмт хувцас, гадаад төрхийн тогтоосон шаардлагыг зөрчих.

5.2 Давтан, аюулгүй байдалтай холбоотой зөрчил.

Дараах үйлдлийг хориглоно:
5.2.1 Сахилгын зөрчлийг удаа дараа давтан гаргах, өгсөн анхааруулга, биелүүлэхгүй байх;
5.2.2 Хичээл таслах, эсхүл хичээл таслахыг уриалах, зохион байгуулах;
5.2.3 Бусдын эд хөрөнгийг зөвшөөрөлгүй авах, ашиглах, хайхрамжгүй байдлаар гэмтээх, бохирдуулах;
5.2.4 Багш, ажилтанд худал мэдээлэл өгөх, чөлөө авах, хичээлээс гарах, хоцрох, таслахтай холбоотой мэдээллийг санаатайгаар буруу мэдүүлэх;
5.2.5 Урт хумсаар бусдыг гэмтээж, зөрчил гарган хохирол учруулсан;
5.2.6 Осол, гэмтэл, аюултай нөхцөл байдал, дээрэлхэлт, дарамт, хүчирхийллийн талаар мэдсэн атлаа нуун дарагдуулах, худал мэдээлэх;
5.2.7 Насны шаардлага хангаагүй суралцагч цахилгаан дугуй, скүүтэр унаж ашиглах;
5.2.8 Шалгалт, даалгавар, бие даалт, бүтээлч ажилд AI, интернет эсвэл бусад эх сурвалжийг багшийн зөвшөөрөлгүй шударга бус давуу байдал бий болгох зорилгоор ашиглах;
5.2.9 Интернэт болон бусад эх сурвалжаас авсан материалыг эх сурвалж заалгүй ашиглах, өөрийн мэтээр танилцуулах;
5.2.10 Сошиал сүлжээ, мессенжер, тоглоомын платформ зэрэгт бусдыг доромжлох, заналхийлэх, тусгаарлах, цахимаар дээрэлхэх;
5.2.11 Бусдын зөвшөөрөлгүй хувийн зураг, видео, дуу бичлэг, чат, дэлгэцийн хуулбарыг нийтлэх, дамжуулах.
5.2.12 Хичээлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг багшийн хяналт, зөвшөөрөлгүй хэрэглэх;
5.2.13 Хуулиар болон сургуулийн дотоод журмаар хориглосон төрлийн хоол, хүнс, ундаа, бүтээгдэхүүнийг сургууль дотор оруулах;

5.2.14 Өөртөө болон бусдад гэмтэл учруулж болзошгүй үйлдэл, тухайлбал түлхэх, гүйж мөргөлдөх, боох, цохих, гэх мэт аюултай тоглоом, үйлдэл гаргахгүй байх;

5.3 Ноцтой, аюултай, захиргааны түвшинд шууд авч үзэх зөрчил

Аюулгүй байдалтай холбоотой зөрчлийг давтан гаргасан буюу дараах үйлдлийг гаргасан бол ноцтой зөрчилд тооцно. Үүнд:

5.3.1 Бүх төрлийн тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, бусдад өгөх, сургуульд авч ирэх;
5.3.2 Бусдын бие махбод, амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйд халдах, заналхийлэх;
5.3.3 Дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, айлган сүрдүүлэх, заналхийлэх ноцтой, давтан хэлбэрийн үйлдэл гаргах;
5.3.4 Сургуульд автомашин, мотоцикл, квадроцикл, суррон болон тусгай зөвшөөрөл шаардсан техник хэрэгсэл жолоодож ирэх;
5.3.5 Зэвсэг, хурц иртэй, шовх үзүүртэй, шатах, дэлбэрэх, химийн болон бусдыг гэмтээж болзошгүй эд зүйл, бодис авч ирэх;
5.3.6 Сургуулийн барилга, байгууламж, эд хөрөнгө болон бусдын эд хөрөнгийг санаатайгаар гэмтээх, бохирдуулах;
5.3.7 Бусдын эд хөрөнгийг хулгайлах;
5.3.8 Багш, ажилтан, суралцагчдыг биечлэн болон цахимаар доромжлох, гутаах, гүтгэх, айлган сүрдүүлэх, дарамтлах;
5.3.9 Цахим орчинд худал мэдээлэл тараах, гүтгэх, доромжлох, заналхийлэх, бусдын зураг, мэдээллийг зөвшөөрөлгүй тараах, дарамтлах;
5.3.10 Насны хязгаартай, хориглосон аудио, видео, контент үзэх, хадгалах, тараах, сурталчлах;
5.3.11 Аливаа суралцагч, багш, ажилтны эсрэг бусдыг турхирах;
5.3.12 Бусдын хувийн нууц, захидал харилцаа, мэдээ мэдээллийг зөвшөөрөлгүй задруулах;
5.3.13 AI ашиглан бусдын зөвшөөрөлгүй хуурамч зураг, аудио, видео бичлэг, эвлүүлэг хийж тараах;
5.3.14 AI ашиглан хортой код, вирус, фишинг контент, мэдээлэл хулгайлах хэрэгсэл үүсгэх, бусдад тараах;
5.3.15 AI-аар үүсгэсэн хуурамч контент, мэдэгдэл, баримт бичгээр хууран мэхлэх, төөрөгдөл үүсгэх, сургуулийн нэрийн өмнөөс тараах;
5.3.16 Бусдын нууц үг, данс, хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, бусдад тараах, дамжуулах;
5.3.17 Сургуулийн цахим систем, веб сайт, сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх, өөрчлөх, ашиглах;
5.3.18 Гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргах, түүнд оролцох, бусдыг татан оролцуулах;
5.3.19 Эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүсгэж болзошгүй эм, бэлдмэл, бодисыг сургуулийн эмч, багш, холбогдох ажилтанд мэдэгдэлгүй авч явах, хэрэглэх, бусдад өгөх;
5.3.20 Сургуулийн цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөвшөөрөлгүй оролдох;
5.3.21 Хүн орохыг хориглосон тэмдэгтэй өрөө, танхимд дур мэдэн нэвтрэх ашиглах;
5.3.22 Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, гадаад төрх, шашин шүтлэг болон бусад ялгаатай байдлаар хэн нэгнийг доромжлох, хочлох, гадуурхах, цахимаар гутаах.

6. Хариуцлага

6.1 Өдөр тутмын дэг, сахилгын зөрчил.д авах арга хэмжээ

Анх удаагийн өдөр тутмын дэг, сахилгын зөрчилд хичээлийн багш, анги удирдсан багш эсхүл холбогдох ажилтан амаар сануулж, алдаагаа засах боломж олгоно.

6.2 Аюулгүй байдалтай холбоотой зөрчилд авах арга хэмжээ

Өдөр тутмын дэг, сахилгын зөрчил давтан гаргасан буюу аюулгүй байдалтай холбоотой зөрчил гаргасан тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчид мэдээлж, суралцагчид тодорхой үүрэг, анхааруулга өгч сургалтын алба, холбогдох удирдлагад мэдэгдэн, бичгэн сануулга өгнө.

6.3 Ноцтой, аюултай, захиргааны түвшинд шууд авч үзэх зөрчилд авах арга хэмжээ

Аюулгүй байдалтай холбоотой зөрчил давтан гаргасан буюу ноцтой, аюултай, захиргааны түвшинд шууд авч үзэх зөрчил гаргасан тохиолдолд бусад суралцагч, багш, ажилтан болон бусдын аюулгүй байдал, эд хөрөнгө, нэр төр, алдар хүндийг хамгаалах үүднээс сургуулиас түр хугацаагаар хязгаарлах, тусгай хяналттай нөхцөл тогтоох, гэрээний нөхцөл сануулах, шаардлагатай тохиолдолд сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авч болно.

Тус зөрчил нь хууль, хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын онцгой кейсийн шинжтэй бол холбогдох байгууллагад шилжүүлнэ.

Уншиж, танилцсан:

... ангийн суралцагч: _____ / /

Эцэг эх, асран хамгаалагч: _____ /